

**ЭНЭ МЭДЭЭГ ОДООНООС АШИГЛАЖ БОЛНО.**

## **Хэвлэлийн мэдээ**

№. 14-08

2014 оны 7 дугаар сарын 8-ны өдөр

**JENESYS 2.0 хөтөлбөрт оролцохоор Япон улсыг зорьсон Монголын орон нутгийн ахлах сургуулийн сурагчид өнөөдөр нутагтаа ирнэ**

JENESYS 2.0 хөтөлбөрийн хүрээнд 7 дугаар сарын 1-нээс 8-ны өдрүүдэд Япон улсад зочилсон Монголын орон нутгийн ахлах сургуулийн 50 сурагч өнөө орой (7 сарын 8-ны өдрийн 23:40 цагт ОМ224 нислэгээр) нутагтаа ирнэ.

Оролцогчид Япон улсын нийслэл Токио хоттой танилцсаны дараа 2 хэсэгт хуваагдан Иватэ мужийн Күжи хот, Миязаки мужийн Мияконожёо хотод айлчилсан юм. Тэд Японы орон нутгийн захиргаа болон тухайн орон нутгийн компани, аж ахуйн нэгжүүдтэй танилцаж, япон айлд зочлон, орон нутгийн ард иргэдтэй уулзаж, түүхийн дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт сайхан газруудаар аялсан.

Энэхүү харилцааны хөтөлбөрөөр дамжуулан Монголын залуучуудад Японы орон нутгийн бахархал, үндэсний соёл уламжлалыг таниулахаас гадна япон брэнд болон “Японы үнэт зүйлс”-ийн талаархи ойлголт, сонирхлыг улам бүр гүнзгийрүүлж чадсан хэмээн найдаж байна.

JENESYS 2.0 хөтөлбөрийн тухай

Япон улсын Ерөнхий сайд Ш.Абэ 2013 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Индонези улсад хийсэн албан ёсны айлчлалынхаа үеэр 2007 оноос хэрэгжүүлж эхэлсэн “XXI зууны Зүүн Азийн хүүхэд залуусын өргөн хүрээний харилцааны хөтөлбөр (JENESYS)-ийг үргэлжлүүлж, Ази, Номхон далайн улс орнуудын 30,000 хүүхэд залуусыг хамарсан JENESYS 2.0 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээ мэдэгдсэн юм.

Энэхүү хөтөлбөр нь Япон улсын эдийн засгийг сэргээх зорилтын хүрээнд гадаад иргэдийн Японы талаархи сонирхлыг нэмэгдүүлж, Япон улсыг зорих гадаад иргэдийн тоог өсгөхийн сацуу Cool Japan буюу Японы онцлог ба бахархал, япон брэнд, мөн түүнчлэн “Японы үнэт зүйлс”-ийн талаарх ойлголтыг олон улсад түгээн дэлгэрүүлэх зорилготой юм.

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллага болох Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Төв /JICE/-ийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг <http://sv2.jice.org> эндээс авна уу.

Оролцогчдыг нисэх буудалд буусны дараа ярилцлага авахыг хүсвэл Японы Элчин Сайдын Яамны ажилтан С.Мөнхжаргалтай холбогдоно уу.

Утас: 11-320777

---

---

**ЯПОН УЛСААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ЭЛЧИН САЙДЫН ЯАМ**

**ЛАВЛАХ УТАС:320777**